

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН СОЁЛЫН БАЙГУУЛЛАГУУДААС “ХОС БИЧИГТЭН БАЙГУУЛЛАГА” АРГА ХЭМЖЭЭНИЙ ХҮРЭЭНД ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛЫН ТАЙЛАН

2023.11.24

Дархан-Уул аймаг

Соёлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2 дахь заалт, Монгол хэлний тухай хууль 7 дугаар зүйлийн 7.2 дахь заалт, “Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын зорилт 1.3, Монгол Улсыг 2020-2025 онд хөгжүүлэх үндсэн таван чиглэлийн төлөвлөгөөний 1.3, Соёлын яамны стратеги төлөвлөгөөний 4.2, “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр-III”-ын Монгол бичгийн нийтийн хэрэглээний орчин бий болгох, түгээн дэлгэрүүлэх ажлыг хэрэгжүүлэх үүрэг бүхий дэд ажлын хэсгийн төлөвлөгөөний 3.1 дэх ажлын хүрээнд нийтдээ **16** арга хэмжээ, **22** сургалт, **126** зурагт хуудас, контент, **22** албан бичиг, **8** албан хаагчийн нэрийн хуудас, **7** ажилтны ажлын үнэмлэх болон ажлын байрны гадна болон дотор хаягжилтыг монгол бичгээр үйлдэх зэргээр олон талт арга хэмжээнүүдийг зохион байгуулж ажиллалаа. Үүнд:

Аймгийн Соёл, урлагийн газар:

Тус аймгийн Соёл, урлагийн газар, Хүүхдийн номын ордон нь албан бланкаа монгол бичгээр хөрвүүлэн боловсруулан Дархан-Уул аймгийн Архивын тасагт хандан хянуулж, нийт **22 албан бичиг** солилцсон байна. Харин Залуучууд театр, Музей, Төв номын сан, Шарын гол, Хонгор, Орхон сумдууд албан бланкыг монгол бичгээр боловсруулан аймгийн Архивын тасагт хянуулахаар хүргүүлсэн.

Соёлын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2021 оны А/148 дугаар тушаалын дагуу соёлын байгууллагуудын албан хаагчдад монгол бичгийн сургалтыг **6 удаа** зохион байгуулж, мэдлэг ур чадварыг нь дээшлүүлэн соён гэгээрүүлэх ажлыг хийж гүйцэтгэсэн.

1. Төрийн байгууллага хоорондын уялдаа холбоог бэхжүүлэх хүрээнд жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг “Үндэсний бичиг үсгийн баяр”-ын хүрээнд Төв номын сангаас төрийн байгууллагуудын төлөөлөл бүхий нийт 40 гаруй төрийн албан хаагчдын дунд “**Миний монгол бичиг**” сургалт, өдөрлөгийг тус газар нь Дархан-Уул аймаг дахь ТАЗСЗ, ГБХЗХГ, аймгийн Хэлний бодлогын зөвлөл, ГБХЗХГ-тай хамтран 30 дугаар сургууль дээр амжилттай зохион байгууллаа.




Зураг-1. "Мянган жилийн буурал түүхтэй Монгол бичиг соёлоо судалцаая" сэдвээр 30 дугаар сургуулийн сургалтын менежер Ж.Эрхэмсайхан, Үндэсний бичиг үсгийг "Сав, шим" ертөнцийн юмс, үзэгдэлтэй холбон таних арга ба үр дүн сэдвээр Боловсрол судлалын ухааны доктор Ц.Буянхишиг багш нар лекц тавьсан нь /2023.05.08/




Зураг-2. Төв номын сангаас 100 гаруй боть номоор "Монголчуудын эртний бичгийн сурвалж судалгаа" сэдэвчилсэн номын үзэсгэлэн, аймгийн Музей "Монголчуудын хэрэглэж ирсэн бичгийн хэрэгсэл" үзэсгэлэн, 30-р сургууль, Од цогцолбор сургуулийн багш сурагчдын бүтээлийн үзэсгэлэн гаргасан нь /2023.05.08/

2. “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр-III”-ийн хүрээнд төрийн бүх шатны байгууллагууд монгол бичгийн цахим бичвэрийн орчин бүрдүүлэх, төрийн албан хаагчдын монгол бичгийн мэдлэг, чадварыг дээшлүүлэх зорилгоор тус газрын 7 албан хаагчдыг монгол бичгийн анхан, дунд шатны сургалтуудад хамруулж чадавхжуулсан.




Зураг-3. Сургалтыг аймгийн Хүүхдийн номын ордны Монгол хэлний танхимын багш Ц.Наранцэцэг удирдан явуулсан нь /2023.01.02-2023.01.31/


3. Хос бичигтэн хөтөлбөрийн хүрээнд Үндэсний бичиг сурах анхан шатны хичээлүүд болон контентуудыг пэйж хуудсанд байршуулж хичээлүүдийг тус газрын албан хаагчид бие даан судалж, өдөр тутмын үйл ажиллагаандаа ашиглаж хэвшсэн.



Зураг-4. Монгол бичгийн хичээлийг сувгийг дагаж өдөрт нэг хичээлийг бие даан судалж байгаа нь /2023.11.01/



Зураг-5. Тус газраас 2 албан хаагч Удирдлагын академийн анхан, дунд, ахисан түвшний цахим сургалтад хамрагдаж, сертификат авсан нь /2023.10.23/




Зураг-6. Тус газрын 7 албан хаагчид монгол бичгээр “Уран бичлэг”-ийн сургалт авсан нь /2023.11.22/

4. Тус газарт хэрэглэгддэг А4, А5 албан бланкуудыг монгол бичгээр хөрвүүлсэн төслийг хянуулах хүсэлтээ аймгийн Архивын тасагт албан ёсоор хүргүүлж баталгаажуулж, албан ёсны эрхтэй хэвлэлийн компаний хэвлэлтэд оруулсан.



Зураг-7. Баталгаажуулсан албан бланкны загвар /2022.09.29/



Зураг-8. 2023 онд албан хэргээ хос бичгээр хөтлөн явуулах ажлыг туршиж, нийт 22 албан бичгийг монгол бичгээр хослуулан харьяа болон дээд байгууллага руу илгээсэн нь




Зураг-9. Байгууллагын дотор хаягжилт, албан хаагчдын нэрийн хуудсыг монгол бичгээр хэвлүүлсэн нь. /2023.02.15/



Зураг-10. Байгууллагын гаднах хаягжилтыг монгол бичгээр хослуулан үйлдэж байрлуулсан нь /2023.09.25/

5. 2022-2023 онуудад тус газар нь Монгол бичгийн нийгмийн хэрэглээг дэмжих соёлын олон талт арга хэмжээ зохион байгуулах тухай мэдээллийг монгол бичгээр үйлдэн 126 зураг хуудас, видео бичлэгийг бэлтгэн сошиал болон байгууллагын вэб сайтад тогтмол байршуулж, иргэд олон нийтэд мэдээлэл хүргэжээ.



Зураг-11. Тус газрын 8 албан хаагч “Бийрэн бичлэг”-ийн сургалтад хамрагдсан тухай зурагт постерыг сошиалиар түгээсэн нь /2023.11.23/




Зураг-12. “Үндэсний бичиг, соёл” Номын баяр-2023 арга хэмжээний зурагт постер дээр монгол бичгээр хослуулан үйлдэж байршуулсан нь /2023.05.17, 2023.09.15/

6. “Нүүдэлчин” дэлхийн соёлын фестиваль-2023 арга хэмжээнд тус аймгийн 30 дугаар сургуулийн менежер Ж.Эрхэмсайхан соёлын биет бус өвийн яаралтай хамгаалах шаардлагатай өвд хамаарах Ном бүтээх уламжлалт урлалаар мянган жилийн буурал түүхтэй эртний түүхт “Хуйлмал ном”-ыг урлан нүүдэлчин монголчууддаа дэлгэн танилцуулж оролцсон.



Зураг-13. “Хуйлмал ном”-ыг Дархан-Уул аймгийн Монцамэ агентлагтай хамтран видео контент бэлтгэн байгууллагын пэйж, цахим хуудсанд тус тус байршуулж, олон нийтэд түгээж сурталчилсан нь /2023.08.25/ **Линкийг доор байрлуулав.**

<https://www.facebook.com/100064046435308/videos/1672854539880511/>



Зураг-14. Монгол Улсын Соёлын яам болон ЗГХА СУГ-ын “Үндэсний бичгээ сурч, хос бичигтэн болцгооё” уриан дор хэрэгжүүлж буй видео бичлэг, зураг хуудас, хичээлийг тогтмол хуваалцаж пэйж, цахим хуудсанд байршуулсан нь /2023.09.02/

7. “Соёлын сэргэлт” аяны хүрээнд Шарын гол суманд “Үндэсний бичиг үсэг, өв соёлоо эрхэмлэн дээдэлье” уриан дор Монгол хэл, уран зохиолын багш нар сумын иргэдийн дунд үндэсний бичгээр уншсан иргэдэд “Бийрэн бичлэг”-ээр нэрийг нь бичсэн бичвэр, номын хавчуурга, талархал зэргийг дурсгалаа.



Зураг-15. Тус газрын албан хаагчид монгол бичгээр зөв, шударга унших тэмцээнд оролцсон нь /2023.09.27/

Бичлэгийн линкийг доор байршуулав.

<https://www.facebook.com/100006891911668/videos/pcb.3479909648932569/175047985574998>


Хүүхдийн номын ордон:

Үндэслэл: “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III”-ын Монгол бичгийн нийтийн хэрэглээний орчин бий болгох, түгээн дэлгэрүүлэх ажлыг хэрэгжүүлэх үүрэг бүхий Дэд ажлын хэсгийн төлөвлөгөөний 3.1 “Албан хэргийг кирилл болон үндэсний бичгээр хөтлөн явуулах, цаашид монгол бичигт бүрэн шилжих эрх зүй, технологийн орчин бүрдүүлэх ажлын хүрээнд дараах ажлуудыг зохион байгууллаа. Үүнд:

1. “Хүмүүн бичиг сонин”-оос “**Уншиж хэвшигчээ**” уриатайгаар “Кофетой уншлага”-ыг 2 дахь жилдээ зохион байгуулж гадаад үг нүдэлж тогтоох, цаг үеийн мэдээ мэдээллийг уншин танилцаж, бусадтайгаа харилцан ярилцаж хэлэлцүүлэг хийж, ажилчдын компьютер монгол бичгийн фонд суулгаж, үндэсний бичгээр цахимаар бичиж сурч байна.



Зураг-1. 2023 оны 11 дүгээр срын 20-ны тус ордны 11 албан хаагчид өглөөний сургалтад хамрагдлаа.



Зураг-2. “Үндэсний бичгээр хурдан бичих” ур чадварын уралдаанд 2 албан хаагч амжилттай оролцлоо. /2023.05.18/

2. Хүүхдийн номын ордны сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт, Үндэсний бичиг үсгийн баярын өдөр”-т зориулан тус ордны ажилтан, албан хаагчдыг монгол бичгийн мэдлэг чадварыг дээшлүүлэх, эх хэлээрээ зөв бичиж, зөв ярьж сурах дадал хэвшил төлөвшүүлэх зорилгоор 2023 оны 09 дүгээр сарын 05-ны өдөр тус ордны нийт 15 ажилтан албан хаагчдын дунд “Зөв бичиж, зөв ярья” сургалтыг зохион байгууллаа. Сургалтыг Монгол хэл бичиг, уран зохиолын танхимын номын санч-мэдээллийн ажилтан Ц.Наранцэцэг удирдан зохион байгууллаа.

Сургалтаар ихэвчлэн алддаг үг, ижил дуудлагатай, агуулга өөр үгүүдийг хэрхэн бичдэг талаар тайлбарлав. Мөн үгээс үг үүсгэх, хамгийн урт бичлэгтэй үг таах зэрэг хөгжөөнт тоглоом тоглож, авхаалж самбаагаа сорилоо.



Зураг-3. Тус ордны 15 албан хаагчид “ Зөв бичиж, зөв ярья” сургалтыг авлаа. /2023.09.05/

3. “Хос бичигтэн байгууллага” арга хэмжээний хүрээнд аймгийн Соёл урлагийн газрын 7 албан хаагчдыг Монгол бичгийн анхан, дунд шатны сургалтад хамрууллаа.

Зураг-4.



Танхимаар үйлчлүүлж буй уншигчдадаа Монгол бичгийн сургалт тогтмол зохион байгуулж байна. **Зураг-5.**



4. Тус ордны монгол бичгээр үйлдсэн албан бланкийг 2023 оны 09 дүгээр сарын 06-ны өдөр аймгийн Архивын газарт хүргүүлсэн. Одоогоор монгол бичгээр хослуулан 9 албан бланкийг бусад байгууллагад хүргүүлсэн байна. **Зураг-6**



5. Тус ордны хаягжилт албан хаагчдын нэрийн хуудас, байгууллагын албан хаагчдын өрөө, тасалгааны хаягийг шинэчилж хос бичигтэй болгосон. /2023.02.01/ **Зураг-7**



6. Үндэсний бичиг үсгийн баяр буюу “Номын баяр-2023” арга хэмжээний үеэр тус ордны албан хаагчид Монгол бичгээр өөрийн нэр, хаягаа зөв бичин өөрсдийн танилцуулгаараа “Миний нэрийн хуудас” үзэсгэлэн гаргалаа.

МОНГОЛЫН БИЧИГЧИЙН НЭГЭЭЛЭЛЭЛЭГ
 БЭГДЭЭСЭЭ БИЧИГЧИЙН НЭГЭЭЛЭЛЭЛЭГ
 МОНГОЛЫН БИЧИГЧИЙН НЭГЭЭЛЭЛЭЛЭГ
 МОНГОЛЫН БИЧИГЧИЙН НЭГЭЭЛЭЛЭЛЭГ

МОНГОЛЫН БИЧИГЧИЙН НЭГЭЭЛЭЛЭЛЭГ
 БЭГДЭЭСЭЭ БИЧИГЧИЙН НЭГЭЭЛЭЛЭЛЭГ
 МОНГОЛЫН БИЧИГЧИЙН НЭГЭЭЛЭЛЭЛЭГ
 МОНГОЛЫН БИЧИГЧИЙН НЭГЭЭЛЭЛЭЛЭГ

МОНГОЛЫН БИЧИГЧИЙН НЭГЭЭЛЭЛЭЛЭГ
 БЭГДЭЭСЭЭ БИЧИГЧИЙН НЭГЭЭЛЭЛЭЛЭГ
 МОНГОЛЫН БИЧИГЧИЙН НЭГЭЭЛЭЛЭЛЭГ
 МОНГОЛЫН БИЧИГЧИЙН НЭГЭЭЛЭЛЭЛЭГ

МОНГОЛЫН БИЧИГЧИЙН НЭГЭЭЛЭЛЭЛЭГ
 БЭГДЭЭСЭЭ БИЧИГЧИЙН НЭГЭЭЛЭЛЭЛЭГ
 МОНГОЛЫН БИЧИГЧИЙН НЭГЭЭЛЭЛЭЛЭГ
 МОНГОЛЫН БИЧИГЧИЙН НЭГЭЭЛЭЛЭЛЭГ

МОНГОЛЫН БИЧИГЧИЙН НЭГЭЭЛЭЛЭЛЭГ
 БЭГДЭЭСЭЭ БИЧИГЧИЙН НЭГЭЭЛЭЛЭЛЭГ
 МОНГОЛЫН БИЧИГЧИЙН НЭГЭЭЛЭЛЭЛЭГ
 МОНГОЛЫН БИЧИГЧИЙН НЭГЭЭЛЭЛЭЛЭГ

МОНГОЛЫН БИЧИГЧИЙН НЭГЭЭЛЭЛЭЛЭГ
 БЭГДЭЭСЭЭ БИЧИГЧИЙН НЭГЭЭЛЭЛЭЛЭГ
 МОНГОЛЫН БИЧИГЧИЙН НЭГЭЭЛЭЛЭЛЭГ
 МОНГОЛЫН БИЧИГЧИЙН НЭГЭЭЛЭЛЭЛЭГ

МОНГОЛЫН БИЧИГЧИЙН НЭГЭЭЛЭЛЭЛЭГ
 БЭГДЭЭСЭЭ БИЧИГЧИЙН НЭГЭЭЛЭЛЭЛЭГ
 МОНГОЛЫН БИЧИГЧИЙН НЭГЭЭЛЭЛЭЛЭГ
 МОНГОЛЫН БИЧИГЧИЙН НЭГЭЭЛЭЛЭЛЭГ

МОНГОЛЫН БИЧИГЧИЙН НЭГЭЭЛЭЛЭЛЭГ
 БЭГДЭЭСЭЭ БИЧИГЧИЙН НЭГЭЭЛЭЛЭЛЭГ
 МОНГОЛЫН БИЧИГЧИЙН НЭГЭЭЛЭЛЭЛЭГ
 МОНГОЛЫН БИЧИГЧИЙН НЭГЭЭЛЭЛЭЛЭГ

МОНГОЛЫН БИЧИГЧИЙН НЭГЭЭЛЭЛЭЛЭГ
 БЭГДЭЭСЭЭ БИЧИГЧИЙН НЭГЭЭЛЭЛЭЛЭГ
 МОНГОЛЫН БИЧИГЧИЙН НЭГЭЭЛЭЛЭЛЭГ
 МОНГОЛЫН БИЧИГЧИЙН НЭГЭЭЛЭЛЭЛЭГ


МОНГОЛЫН БИЧИГЧИЙН НЭГЭЭЛЭЛЭЛЭГ
 БЭГДЭЭСЭЭ БИЧИГЧИЙН НЭГЭЭЛЭЛЭЛЭГ
 МОНГОЛЫН БИЧИГЧИЙН НЭГЭЭЛЭЛЭЛЭГ
 МОНГОЛЫН БИЧИГЧИЙН НЭГЭЭЛЭЛЭЛЭГ

МОНГОЛЫН БИЧИГЧИЙН НЭГЭЭЛЭЛЭЛЭГ
 БЭГДЭЭСЭЭ БИЧИГЧИЙН НЭГЭЭЛЭЛЭЛЭГ
 МОНГОЛЫН БИЧИГЧИЙН НЭГЭЭЛЭЛЭЛЭГ
 МОНГОЛЫН БИЧИГЧИЙН НЭГЭЭЛЭЛЭЛЭГ

МОНГОЛЫН БИЧИГЧИЙН НЭГЭЭЛЭЛЭЛЭГ
 БЭГДЭЭСЭЭ БИЧИГЧИЙН НЭГЭЭЛЭЛЭЛЭГ
 МОНГОЛЫН БИЧИГЧИЙН НЭГЭЭЛЭЛЭЛЭГ
 МОНГОЛЫН БИЧИГЧИЙН НЭГЭЭЛЭЛЭЛЭГ

Зураг-8. Хүүхдийн номын ордны албан хаагчдын танилцуулга үзэсгэлэн. /2023.09.19/


7. Монгол бичгийн нийгмийн хэрэглээг дэмжих соёлын олон талт арга хэмжээ зохион байгуулан контент бэлтгэн олон нийтэд хүргэх зорилгоор тус ордноос санаачлан 2022.11.09-ний өдөр “Үндэсний бичиг-манай хамт олны өв соёл” контентын уралдаанд оролцож Тусгай байр эзэллээ.



Зураг-9. Контентын бичлэгийг доор линкээр байршуулав.

<https://www.facebook.com/100003561543793/videos/846300089904116/>

8. “Уншихад Урам хайрла” видео контентод “Бийрэн бичлэг”-ийн уралдаанд шагналт байр эзэлсэн сурагчидтай “Эх хэл бидний бахархал” сэдвээр ярилцлага хийж цахим хуудсандаа байршуулан олон нийтэд хүргэсэн. **/Линкийг доор байршуулав/**



Зураг-10. Тус ярилцлагыг 2022.11.22-ны өдөр хийв. Уралдааны бичлэгийн линкийг хавсаргав.

https://www.facebook.com/watch/?extid=CL-UNK-UNK-UNK-AN_GK0T-GK1C&mibextid=Nif5oz&v=183566550838743

Дархан-Уул аймгийн Төв номын сан:

Үндэслэл: “Алсын хараа- 2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын зорилт 1.3, Монгол хэлний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2, “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III”-ын 3.3.5, 3.3.7 дахь хэсгийн хэрэгжилтийг хангах хүрээнд байгууллага болон аймаг орон нутгийн хэмжээнд Үндэсний бичгийг түгээн дэлгэрүүлэх, нийтийн хэрэглээ болгох, сурталчлан таниулах ажлуудыг зохион байгуулж байна.

2022-2023 онд нийт 37 нэр төрлийн 411 үйл ажиллагаа зохион байгуулж, 47019 хүнийг хамруулснаас “Хос бичигтэн” хөтөлбөрийн хүрээнд 70 удаагийн ажлыг зохион байгуулж, 9238 уншигчдад Монгол хэл, бичгийг сурталчилсан байна. Энэ нь тухай жилийн үйл ажиллагааны 19.6% -ийг эзэлж байна.

Мөн Төв номын санд үндэсний бичгийн бичвэр бүхий 3073 нэр төрлийн 7297 боть ном байгаа нь нийт номын фондын 12,9%-ийг эзэлж байна.

1. Монгол бичгийн сургалт зохион байгуулсан тухай

Монгол хэлний тухай хууль, “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр-III”-ын зорилгын хүрээнд 2025 оноос төрийн албан хэргийг кирилл болон үндэсний Монгол бичгээр хөтлөн явуулах, цаашид бүх нийтээр монгол бичигт шилжих бэлтгэлийг хангаж байгаа билээ.

Тиймээс Хос бичигтэн” болох ажлын хүрээнд Монгол бичгийн түвшин тогтоох судалгаанд байгууллагаараа хамрагдаж, түвшингээ тогтоолгож, Монгол бичгийн анхан шатны мэдэгдэхүүнтэй болох, уншиж, бичиж сурах богино хугацааны 24 цагийн сургалтыг зохион байгуулав.

Тус сургалтыг Од цогцолбор сургуулийн Монгол хэл, бичгийн багш Х.Одхүү, Ц.Бадамцэцэг, С.Баасанхүү нар үнэ төлбөргүй явуулж өгсөн бөгөөд “ТАТА ТУНГАА” хөгжөөнт тоглоомоор наадан мэдлэгээ бататгав.



2. Албан хэрэг хөтлөлт

Соёлын яам, Соёл урлагийн газраас чиглэл болгосоны дагуу Монгол бичгээр албан бланк бэлдэн, хянуулах, захиалах ажлыг зохион байгуулаад байна.

Аймгийн Архивын газарт албан бланкыг хянах батлах хүсэлт гаргаж, Дархан принт хэвлэлийн үйлдвэрт хэвлүүлэхээр хүргүүлэв.

3. Хос бичгээр албан бичгийг үйлдсэн тухай

Албан бланкын захиалга өгч баталгаажиж ирээгүй байгаа учир стандартад заасны дагуу бланкаа өөрийн байгууллагын дотоод ажилд ашиглахаар хэвлэж, туршиж байна.

4. Албан байгууллагын хаягжилт, нэрийн хуудасны талаар

Төв номын сангийн ажилтан, албан хаагчид нь өөрсдөө үндэсний бичгийн анхан шатны мэдэгдэхүүнтэй болсон бөгөөд өөрсдийн нэрийн хуудсыг Монгол бичгээр бичүүлэн ашиглаж байна. Мөн байгууллагын өрөө тасалгаа, ажилтнуудын танилцуулга мэдээллийг крилл болон Монгол бичгээр бичиж QR кодоор уншуулан мэдээлэл авах боломжийг бүрдүүлээд байна.

5. Соёл олон нийтийн ажил

“Үндэсний бичиг соёл, номын өдрүүд-2022” үйл ажиллагааг Монгол Улсын Их Хурлын дарга Гомбожавын Занданшатарын ивээл дор “ИЛҮҮ ИХ УНШЪЯ” уриатайгаар Номын баярыг арга хэмжээ хавар, намрын улиралуудад Соёлын яамны чиглэл, удирдлагын хүрээнд амжилттай зохион байгууллаа.

Улс орон даяар зохион байгуулсан тус үйл ажиллагааг аймгийн Төв номын сангийн захирлын 2022 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн “Үндэсний бичиг соёл, номын өдрүүд”-

ийг тэмдэглэн өнгөрүүлэх тухай тушаал, төлөвлөгөөний дагуу 2 долоо хоногийн хугацаанд бүх шатны байгууллага, иргэд, уншигч олны дунд хүртээмжтэй байдлаар явуулж Соёл урлагийн газар, Төв номын сан, Музей, Залуучууд театр, Хүүхдийн номын ордон, бүх шатны боловсролын байгууллагууд зэрэг нийт 11 байгууллагын 90 гаруй ажилтан, албан хаагчид, СӨБ-ын байгууллагын 120 орчим хүүхэд багачууд, ЕБС-ийн 120 гаруй сурагч, 18 багийн ахмадын зөвлөлийн 230 гаруй ахмадууд номын баярын хөтөлбөрийн үйл ажиллагаанд оролцов.

	Ажил үйлчилгээ	Зохиогдсон ажлын нэр	Орол-цогч	Хаана, хэнд зориулсан
1.	2022 онд нийт 43 удаа сургалт явуулж, давхардсан тоогоор 742 хүн оролцсоноос	Монгол Улсын Үндэсний хөтөлбөр: “Хос бичигтэн” сургалт	14	МУ-ын Үндэсний хөтөлбөрийн “Хос бичигтэн” болох ажлын хүрээнд Монгол бичгийн түвшин тогтоох судалгаанд хамрагдаж Монгол бичгийн 24 цаг
2.	СУРГАЛТ: 43 удаа, 742 хүн	Монгол бичгийн болон бийрэн бичлэгийн богино хугацааны сургалт	15	“Од” цогцолбор сургуулийн Монгол хэл, бичгийн багш Х.Одхүү /анхан шатны мэдлэг олгох/, С.Баасанхүү/бийрээр уран бичих/, Ц.Бадамцэцэг /цахимаар монгол бичгээр бичих арга/ зэрэг багш нар зааж сургалаа. “ТАТА ТУНГАА” хөгжөөнт тоглоомоор сонирхолтой хичээлээ оруулав.
3.	Хурал удаа 1	“Эрдэм шинжилгээний хурал”	45	Соёлын байгууллагуудын хамарсан Хос бичигтэн сургалтанд монгол бичгээр бичих, гар утас ашиглах, үг хайх, галиглах, апп-суулгах, фонд суулгах зэргийг сурсан. /2022.11.17/
4.	Хурал удаа 1	“Эрдэм шинжилгээний хурал”	45	Төв номын сангаас санаачилан Ахмадын хөгжлийн төвтэй хамтран зохион байгуулав.

Монгол бичгийн сургалт

Монгол хэлний тухай хууль, “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр-III”-ын зорилгын хүрээнд 2025 оноос төрийн албан хэргийг кирилл болон үндэсний монгол бичгээр хөтлөн явуулах, цаашид бүх нийтээр монгол бичигт шилжих бэлтгэлийг хангаж байгаа билээ. Төв номын сангийн хамт олон Од цогцолборын Монгол хэл, бичгийн багш Х.Одхүү, Ц.Бадамцэцэг, С.Баасанхүү нарын дэмжлэгтэйгээр Монгол бичгийн анхан шатны мэдэгдэхүүнтэй болох, уншиж, бичиж сурах 3 сарын хугацаатай сургалтанд хамрагдав.



Үндэсний бичиг соёл, номын өдрүүдэд зориулсан Эрдэм шинжилгээний хурал боллоо

Аймгийн Төв номын сан, Ахмадын хөгжлийн төв хамтран "Үндэсний бичиг үсэг-Монгол соёлын үнэт өв" сэдэвт эрдэм шинжилгээний хурлыг зохион байгууллаа. Эрдэм шинжилгээний хуралд:

- ✓ "Үндэсний бичиг үсгийн хэрэглээ" сэдвээр Од цогцолбор сургуулийн Монгол хэлний багш Х.Одхүү,
- ✓ "Үндэсний бичгийг хэрхэн түгээн дэлгэрүүлэх вэ?" сэдвээр Насан туршийн боловсролын төвийн багш Ч.Нансалмаа,
- ✓ "Үндэсний бичгийн цагаан толгойн үсгийг САВ, ШИМ ертөнцийн юмс үзэгдэлтэй холбон таних арга ба үр дүн" сэдвээр Үндэсний лаборатори ОИЦ сургуулийн Монгол хэлний багш Боловсрол судлалын ухааны доктор /Ph.D/ Ц.Буянхишиг,
- ✓ "Соёлын өвийн хадгалалт, хамгаалалт" сэдвээр аймгийн Музейн боловсролын ажилтан М.Мөнхтуяа,
- ✓ "Үндэсний бичиг үсгийн баяр"-ын хэрэгжилт" сэдвээр Төв номын сангийн ахлах номын санч Г.Нямцэнд нар тус тус илтгэл тавьлаа.

Монгол бичгийн сургалтад хамрагдан судалж байгаа ахмад настнууд, Ахмадын хөгжлийн төвийн үйлчлүүлэгчид, XVI дунд сургуулийн 11в ангийн сайн дурын идэвхтэн сурагчид илтгэлүүдийг сонсож, ярилцлага, хэлэлцүүлэг өрнүүлсэн бөгөөд Төв номын сангийн зүгээс "Үндэсний бичиг үсэг-Монгол соёлын үнэт өв" номын үзэсгэлэн, "Миний мөрөөдлийн номын сан" ном бүтээх уралдааны материалын үзэсгэлэн, "Бийрийн эрдэм" уран бичгийн уралдааны бүтээлүүдээр үзэсгэлэн гаргаж толилууллаа.



Уралдаан - 23 удаа 6589 хүн:

1.		“Бийрээр нийлье” монгол бичгийн Уран бичлэгийн уралдаан	35	ЕБС-ийн багш, сурагчид оролцов.
2.		Бийрийн эрдэм монгол бичгийн уран бичлэгийн уралдаан	28	ЕБС-ийн 9-12 дугаар ангийн сурагчид
3.		Монгол бичиг Монгол бахархал монгол бичгийн түргэн уншлагын уралдаан	316	Аймгийн нийт ЕБС-ийн 9 дүгээр ангийн сурагчдын дунд зохион байгуулж, нийт 10 сургуулийн сурагчид оролцож, өгөгдсөн сэдвүүдээс минутын уншлага хийлээ.

"БИЙРЭЭ НИЙЛЬЕ" уран бичлэгийн уралдаан

Аймгийн Төв номын сан нь Монгол бичиг үсэг, өв соёлоо сурталчилсан төрөлжсөн уралдаан тэмцээн, эрдэм шинжилгээний хурал, уулзалт, ярилцлага, соёл, уламжлалыг харуулсан цуврал үзэсгэлэнгүүд зэрэг олон нийтэд зориулсан төрөл бүрийн арга хэмжээг бүх шатны сургууль болон бусад байгууллагуудтай хамтран зохион байгуулдаг уламжлалтай. Энэ удаагийн БИЙРЭЭ НИЙЛЬЕ уралдаанд:

1 байр: ОИЦ сургуулийн 12-4 ангийн сурагч Б.Үлэмж

2 байр: 4 дүгээр сургуулийн 11б ангийн сурагч Б.Алтантуяа

3 байр: ОИЦ сургуулийн 12-2 ангийн сурагч Г.Номин

Тусгай байр: 4 дүгээр сургуулийн 11б ангийн сурагч Б.Номин-Эрдэнэ, 18 сургуулийн 10в ангийн сурагч Б.Оюун-Эрдэнэ нар тус тус шалгарлаа.



Олон улсын эмэгтэйчүүдийн баярыг тохиолдуулан аймгийн нийт номын санчдын дунд "Судар эрдэнийн сувдан дагинасууд" цэнгээнт уралдааныг зохион байгууллаа.

Уралдаанд Төв номын сан, Хүүхдийн номын ордон, Их дээд сургуулийн номын санчид, ЕБС-ийн номын санчид, Орхон, Хонгор, Шарын гол сумын номын санчид зэрэг 5 баг өрсөлдөж:

- Сумдын номын санчдын "Монгол хатад" баг 1-р байр

- Их дээд сургуулийн номын санчдын "Эрдмийн хөтөч" баг 2-р байр тус тус эзэллээ.


Түүнчлэн баринтагийн бүтээл дээрээ үндэсний бичгээр өөрийн нэр алдар, товъёогийг бичиж Үндэсний номын санд хүргүүлэв.



"МОНГОЛ ХҮНИЙ ЯЗГУУР МӨН ЧАНАР, АМЬДРАЛЫН ҮНЭ ЦЭНЭ" лекц болов

Үндэсний бичиг соёл, номын өдрүүдийн хүрээнд “МОНГОЛ ХҮНИЙ ЯЗГУУР МӨН ЧАНАР, АМЬДРАЛЫН ҮНЭ ЦЭНЭ” лекцийг нийт иргэдэд зориулан Залуучууд театрт үнэ төлбөргүй зохион байгууллаа. Б.Батгэрэл, Хэл шинжлэлийн ухааны доктор Ц.Буянхишиг, Хэл шинжлэлийн ухааны магистр, тэргүүлэх зэрэгтэй багш Ж.Эрхэмсайхан, Үндэсний бичиг үсгийг дэлгэрүүлэгч АБТА багш Б.Булганчимэг нар оролцов.

Мөн "Нүүдэлчин Монгол" их наадмын Шилдэг өвлөн уламжлагч багш нарын бүтээл болон “Монгол хүний өв соёл” сэдэвчилсэн номын үзэсгэлэнг Дарханчууддаа дэлгэн толилууллаа.



№	Зохиогдсон ажлын нэр	Оролцсон хүний тоо	Хаана, хэнд зориулсан
1.	“Өв соёлоо дээдэлъе” өдөрлөг Хонгор, Шарын гол сум Салхит баг ЕБС	370	Өдөрлөгт 370 хүүхэд оролцсон
2.	Үндэсний бичиг үсгийн баяраар “Өв соёлоо дээдэлъе” өдөрлөг	150	ЕБС-ийн 6 сургуулийн 150 сурагч оролцов.
3.	Үндэсний бичиг үсгийн баяраар “Өв соёлоо дээдэлъе” өдөрлөг	110	Залуучууд театрын их танхимд Онцгой байдлын газрын албан хаагчид
4.	Үндэсний бичиг үсгийн баяраар “Өв соёлоо дээдэлъе” өдөрлөг	300	ЕБС-ийн ахлах ангийн сурагчид

Нүүдэлчин Монгол наадам: Дархан-Уул аймаг тус наадамд 60 гаруй хүний бүрэлдэхүүнтэй оролцсон бөгөөд Аймгийн Төв номын сангийн зүгээс Ахлах номын санч Г.Нямцэнд Соёлын биет бус өвийн гэрийг хариуцан оролцсоноор “Нүүдэлчин Монгол” наадамд оролцогчдын бүтээлийг 7000 гаруй иргэнд сурталчилж, тайлбарлан таниулсаны үр дүнд ШИЛДЭГ ӨВЛӨН УЛАМЖЛАГЧ-аар дараах хүмүүс шалгарлаа.

- ✧ Монгол бичиг QR код" бүтээлээр Дархан-Уул аймгаас оролцогч, багш Б.Булганчимэг,
- ✧ "Эх хэл, аман уламжлал, илэрхийллүүд" төрөлд багш Ж.Эрхэмсайхан,
- ✧ "Байгалийн болон сав шим ертөнцийн тухай мэдлэг, зан үйл" төрөлд багш Ц.Буянхишиг нар шалгарч ШИЛДЭГ ӨВЛӨН УЛАМЖЛАГЧ медаль, мөнгөн шагналаар шагнууллаа.

НОМЫН БАЯР- 2023:

ҮНДЭСНИЙ БИЧИГ СОЁЛ, НОМЫН ӨДРҮҮДИЙН ХҮРЭЭНД “ҮНДЭСНИЙ НОМЫН БАЯР” ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ТАЙЛАН

Д/д	Зохион байгуулагдах ажлууд	Хэдэн удаа	Хүний тоо	Хариуцах эзэн	Гүйцэтгэл
1	"Бийрээ нийлье" үндэсний бичгийн уралдаан	1	56	Хэлний бодлогын зөвлөл	ЕБС-ийн сурагчдын дунд зохион байгуулж, 1-3-р байр эзлүүлэн дүгнэв.
2	Цахим бичвэрийн уралдаан	1	36	Хэлний бодлогын зөвлөл	Аймгийн ЗДТГ-ын хурлын танхимд Төрийн албан хаагчдын дунд зохион байгууллаа.
3	Монгол бичгийн түргэн уншлагын уралдаан	2	146	МАА, ЗАА, Уншлага үйлчилгээ	Төрийн албан хаагчдад болон ЕБС-ийн сурагчид, насанд хүрэгчдийн дунд 2 удаа зохион байгууллаа.
4	"Үндэсний бичиг үсгийн баяр"-ын хүрээнд Төв номын сангаас аймгийн нийт Төрийн алба хаагчдад зориулан "Миний Монгол бичиг" сургалт, өдөрлөгийг зохион байгууллаа.	1	80	Залуучуудын хөгжлийн төв	Боловсрол судлалын ухааны доктор Ц.Буянхишиг, 30 дугаар сургуулийн сургалтын менежер Ж.Эрхэмсайхан нар лекц тавилаа.

"ХОС БИЧИГТЭН" ЦАХИМ БИЧВЭР, ТҮРГЭН УНШЛАГЫН УРАЛДААН БОЛОВ

"Үндэсний бичиг үсгийн баярын өдөр"-өөр аймгийн Төрийн албан хаагчдад чиглэсэн үйл ажиллагаанууд хийгдэж байгаа бөгөөд Төрийн албаны салбар зөвлөл, Соёл урлагийн газар, Хэлний бодлогын зөвлөлтэй хамтран "ХОС БИЧИГТЭН" цахим бичвэр, түргэн уншлагын уралдааныг зохион байгууллаа.

Уралдаанд нийт 11 байгууллагын 23 ажилтан албан хаагч оролцож үндэсний бичгээрээ унших, өгөгдсөн эхийг хөрвүүлэн цахим бичвэрт буулгах чадвараа сорьсон бөгөөд

Цахим бичвэрийн уралдааны:

- ✓ 1-р байранд Шинэ Алхам сургуулийн багш н.Наранцэцэг
- ✓ 2-р байранд Дархан сумын ИТХурлын ажлын албаны ажилтан Ц.Шинэцэцэг
- ✓ 3-р байранд Аймгийн ЗДТГазрын ажилтан Х. Учрал
- ✓ Тусгай байранд Төв номын сангийн номын санч Н.Норжмаа

Түргэн уншлагын уралдааны:

- ✓ 1-р байранд Дархан сумын ИТХ-ын ажлын албаны ажилтан Ц Шинэцэцэг

- ✓ 2-р байранд Төв номын сангийн номын санч О.Дунжидмаа
- ✓ 3-р байранд 24-р цэцэрлэгийн багш н.Алтанчимэг
- ✓ Тусгай байранд ГХБХБГазрын мэргэжилтэн Ц.Чулуунцэцэг нар амжилттай оролцлоо.



Дархан-Уул аймгийн Залуучууд театр:

Үндэслэл: “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III”-ын Монгол бичгийн нийтийн хэрэглээний орчин бий болгох, түгээн дэлгэрүүлэх ажлыг хэрэгжүүлэх үүрэг бүхий Дэд ажлын хэсгийн төлөвлөгөөний 3.1 “Албан хэргийг кирилл болон үндэсний бичгээр хөтлөн явуулах, цаашид монгол бичигт бүрэн шилжих эрх зүй, технологийн орчин бүрдүүлэх ажлын хүрээнд дараах ажлуудыг зохион байгууллаа. Үүнд:

1. 2023 оны 04 дүгээр сарын 06-ны өдөр театрын нийт албан хаагчдаас Үндэсний бичгийн түвшин тодорхойлох зорилгоор судалгаа авч сургалтын хэрэгцээг тодорхойлох 1 дүгээр шатны монгол бичгийн сургалтыг зохион байгууллаа.

Судалгаанд ажилтнуудын 90 хувь хамрагдсан. Үүнээс: Анхан шатны – 70%, дунд шатны -10%, ахисан түвшний -10 %.

2. 2023 оны 10 дугаар сарын 11-ний өдөр Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн ажлын албанаас Дархан-Уул аймагт зохион байгуулсан сургалтад тус газраас архивын эрхлэгч, бичиг хэргийн ажилтан нар хамрагдлаа.

Аймгийн Засаг даргын 2023 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн /.../ 2023 дугаар албан ёсны хэвлэлт

ХЭЛНИЙ БОДЛОГЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН АЖЛЫН АЛБАНААС ДАРХАН-УУЛ АЙМАГТ ЗОХИОН БАЙГУУЛАХ СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

Хугацаа: 2023 оны 10 дугаар сарын 11-ний өдөр

Хянаа: Аймгийн Засаг даргын Тамгын газрын журмын заал

ИД	Сургалтын сэдэв	Хугацаа	Багшийн нэр
Хамрагдах: Сум, хэлтэс, агентлагийн албан хаагчид			
1	Монгол бичгийн үндэсний хөтөлбөр-III-ын хэрэгжлтийн явцын танилцуулга	11:00-11:30	Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн Ажлын албаны дарга, доктор Н.Нарангэрэл
2	Үндэсний бичгийн мэдлэг баталгах сургалт	11:30-12:00	Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн Ажлын албаны эзэмшмэл зохиогчид ахлах ажилтан, доктор Д.Цэвээндорж
3	Үндэсний бичгээр цахим бичвэр боловсруулах арга зүйн сургалт	12:00-13:30	Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн Ажлын албаны эзэмшмэл зохиогчид ахлах ажилтан, доктор Д.Цэвээндорж, архив, бичиг хэрэг, дотоод хяналт харуусан ажилтан, магистр Г.Харламцэцэг
Хамрагдах:ЕБС, СӨББ, Дархан-Уулын багийн албан хаагчид			
1	Монгол бичгийн үндэсний хөтөлбөр-III-ын хэрэгжлтийн явцын танилцуулга	14:00-14:30	Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн Ажлын албаны дарга, доктор Н.Нарангэрэл
2	Үндэсний бичгийн мэдлэг баталгах сургалт	14:30-15:00	Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн Ажлын албаны эзэмшмэл зохиогчид ахлах ажилтан, доктор Д.Цэвээндорж
3	Үндэсний бичгээр цахим бичвэр боловсруулах арга зүйн сургалт	15:00-18:30	Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн Ажлын албаны эзэмшмэл зохиогчид ахлах ажилтан, доктор Д.Цэвээндорж, архив, бичиг хэрэг, дотоод хяналт харуусан ажилтан, магистр Г.Харламцэцэг



3. Залуучууд театрын албан бланкийг монгол бичгээр хэвлүүлэхээр 2023 оны 10 дугаар сарын 16-ны өдөр Дархан-Уул аймгийн Архивын тасагт болон “Дархан принт” хэвлэлийн компанид захиалга өгөв.

4. 2023 оны 11 дүгээр сарын 02-ны өдөр байгууллагын ажлын газрын хаягжилт, албан хаагчдын нэрийн хуудсыг монгол бичгээр хэвлүүлэхээр хэвлэлийн компанид захиалга өгсөн.

Дархан-Уул аймгийн Музей:

Үндэслэл: “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III”-ын Монгол бичгийн нийтийн хэрэглээний орчин бий болгох, түгээн дэлгэрүүлэх ажлыг хэрэгжүүлэх үүрэг бүхий Дэд ажлын хэсгийн төлөвлөгөөний 3.1 “Албан хэргийг кирилл болон үндэсний бичгээр хөтлөн явуулах, цаашид монгол бичигт бүрэн шилжих эрх зүй, технологийн орчин бүрдүүлэх ажлын хүрээнд дараах ажлуудыг зохион байгууллаа. Үүнд:

1. Аймгийн Музейн 8 албан хаагчид 2023 оны 05 дугаар сарын 18-ны өдөр “Од” цогцолбор сургуулийн монгол хэл бичгийн Х.Одхүү багшийн удирдлаган дор анхан болон дунд шатны 2 удаагийн монгол бичгийн сургалтад хамрагдлаа.



Зураг-1. Музейн албан хаагчид ажлын байранд монгол бичгийн сургалт авлаа.
/2023.05.18/

2. Дархан-Уул аймгийн Төрийн Архивын тасгаас зохион байгуулсан “Монгол бичгийн цахим бичвэр” сургалтад тайлбарлагч М.Наранцэцэг хамрагдаж цахимаар албан тоот бичих анхан шатны сургалтад хамрагдсан.

3. Дархан-Уул аймгийн Төрийн Архивт Музейгээс 10 дугаар сарын 25-ны №90 тоот албан тоотоор монгол бичгийн бланк захиалах хүсэлтийг хүргүүлсэн. Хэвлэлтэд ороогүй хүлээгдэж байна.

4. 5 дугаар сарын 10-нд жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг “Үндэсний бичиг үсгийн баяр”-ын хүрээнд Музейн сан хөмрөгт хадгалагддаг Ж.Эрхэмсайхан багшийн 18 гар бичмэлүүдээр үзэсгэлэн дэглэсэн бөгөөд тус үзэсгэлэнг 40 гаруй хүүхдүүдэд толилуулав.

5. 5 дугаар сарын 9-нд жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг “Үндэсний бичиг үсгийн баяр”-ын хүрээнд Төв номын сангаас аймгийн нийт Төрийн албан хаагчдад зориулан “Миний Монгол бичиг” сургалт өдөрлөгийг зохион байгууллаа. Аймгийн Музейгээс

Ж.Эрхэмсайхан багшийн бүтээлүүд болон сан хөмрөгт хадгалагдаж буй судар, бичиг үсгийн дурсгалын зургуудаар “Монголчуудын эртний бичгийн сурвалж судалгаа” сэдэвт үзэсгэлэн дэглэж, 20 гаруй төрийн албан хаагчдад толилуулав. **Зураг-2.**



6. Музейн гадна хаяг тайлбарыг крилл болон монгол бичгээр хослуулан хэвлүүлж гаргаж, Музейн нийт 8 албан хаагчдын ажлын үнэмлэхийг хэрэглэж эхлэсэн бөгөөд тус ажлын үнэмлэхэндээ өөрсдийн нэрсийг монгол бичгээр хослуулан бичиж хэвлүүлсэн.

Зураг-3.



Дархан-Уул аймгийн Шарын гол сумын Соёлын төв:

Үндэслэл: “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III”-ын Монгол бичгийн нийтийн хэрэглээний орчин бий болгох, түгээн дэлгэрүүлэх ажлыг хэрэгжүүлэх үүрэг бүхий Дэд ажлын хэсгийн төлөвлөгөөний 3.1 “Албан хэргийг кирилл болон үндэсний бичгээр хөтлөн явуулах, цаашид монгол бичигт бүрэн шилжих эрх зүй, технологийн орчин бүрдүүлэх ажлын хүрээнд дараах ажлуудыг зохион байгууллаа. Үүнд:

1. "Соёлын бүтээлч сар" аяны хүрээнд Шарынол сумын ЕБС-ийнн монгол хэл, бичгийн багш нараас сургалт авч сумын нийт албан байгууллагын хамруулах "Үндэсний бичиг үсгийн соёл" сургалтанд 4 байгууллагын 56 албан хаагч хамрагдсан байна.



2. “Хос бичигтэн байгууллага” арга хэмжээг хэрэгжүүлж Албан хэргээ үндэсний бичгээр хослуулан хэрэглэхэд тус соёлын төвийн албан бланкийг Дархан-Уул аймгийн Архивын тасагт 2023 оны 10 дугаар сарын 12-ны өдөр хүргүүлж, байгууллагын гадна хаяг, албан хаагч нарийн нэрийн хуудсыг монгол бичгээр хэвлүүлэх ажлыг хийж хэвлэлийн компанид захиалга өгсөн.

Дархан-Уул аймгийн Хонгор сумын Соёлын төв:

Үндэслэл: “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III”-ын Монгол бичгийн нийтийн хэрэглээний орчин бий болгох, түгээн дэлгэрүүлэх ажлыг хэрэгжүүлэх үүрэг бүхий Дэд ажлын хэсгийн төлөвлөгөөний 3.1 “Албан хэргийг кирилл болон үндэсний бичгээр хөтлөн явуулах, цаашид монгол бичигт бүрэн шилжих эрх зүй, технологийн орчин бүрдүүлэх ажлын хүрээнд дараах ажлуудыг зохион байгууллаа. Үүнд:

1. 2023 оны 09 дүгээр 20-ны өдөр буюу “Үндэсний бичиг соёл, Номын өдрүүд 2023” арга хэмжээний үеэр сумын ЕБС-ийн 6-7 дугаар ангийн 25 сурагчдын дунд монгол бичгийн “Цэвэр бичигтэн сурагч” шалгаруулах үзэсгэлэнг, “Үндэсний монгол бичиг”-ээр хэрхэн хурдан унших вэ? сэдэвт уралдааныг тус тус зохион байгууллаа.




Зураг-1. Сумын ЕБС-ийн 7 дугаар ангийн сурагчдын бүтээлийг дэлгэв. /2023.09.20/



Зураг-2. “Үндэсний монгол бичиг”-ээр хэрхэн хурдан унших вэ? сэдэвт уралдаан болов. /2023.09.20/

2. “Хос бичигтэн байгууллага” арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллах хүрээнд сумын төрийн албан хаагчдын дунд “Цахим монгол бичиг” сургалтыг зохион байгуулсан.

Үүнд: ТАХ-ыг компьютерт хэрхэн монгол бичгийн фонд суулгах, хэрхэн зөв бичих тухай сургалт юм.



3. 2023 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр “Соёлын бүтээлч сар” аяны хүрээнд 16 дугаар цэцэрлэгийн багш ажилчдын дунд “Үндэсний бичиг соёл” сургалтыг зохион байгуулав.



4. Тус соёлын төвийн албан бланкийг монгол бичгээр хэвлүүлэхээр 2023 оны 11 дүгээр сарын 02-ны өдөр аймгийн Соёл, урлагийн газраас чиглүүлэг авч Дархан-Уул аймгийн Архивын тасагт, мөн тус өдөр байгууллагын ажлын газрын хаягжилт, албан хаагчдын нэрийн хуудсыг монгол бичгээр хэвлүүлэхээр хэвлэлийн компанид захиалга өглөө.

Дархан-Уул аймгийн Орхон сумын Соёлын төв:

Үндэсний нэгдмэл үнэт зүйлийг бэхжүүлэх үүргийн хүрээнд Соёлын төвийн албан хаагчид үндэсний бичгээ бүрэн сурах орчин бүрдүүлж, сурах нөхцөл бололцоог хүн бүрд тэгш хүртээмжтэй үндэсний үзэлтэй иргэнийг төлөвшүүлэхийн тулд Монгол хэл бичгийн багш Ж.Жавзандулам багшаар 7 хоногт 2-3 удаагийн давтамжтай сургалтыг зохион байгуулж байна.


Үндэслэл: “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III”-ын Монгол бичгийн нийтийн хэрэглээний орчин бий болгох, түгээн дэлгэрүүлэх ажлыг хэрэгжүүлэх үүрэг бүхий Дэд ажлын хэсгийн төлөвлөгөөний 3.1 “Албан хэргийг кирилл болон үндэсний бичгээр хөтлөн явуулах, цаашид монгол бичигт бүрэн шилжих эрх зүй, технологийн орчин бүрдүүлэх ажлын хүрээнд дараах ажлуудыг зохион байгууллаа. Үүнд:

1. 2023 оны 11 дүгээр сарын 09-ний өдөр “Соёлын бүтээлч сар”-ын хүрээнд соёлын төвийн албан хаагчид Үндэсний бичгээ бүрэн сурах орчин бүрдүүлж, сурах нөхцөл бололцоог хүн бүрд тэгш хүртээмжтэй үндэсний үзэлтэй иргэнийг төлөвшүүлэх зорилгоор Монгол бичгийн анхан, дунд шатны хичээлийг 7 хоног бүрийн баасан гаригт авч байна.



Сургалтыг Монгол хэл бичгийн багш Ж.Жавзандулам багш удирдан явуулсан юм.

2. Аймгийн Соёл, урлагийн газраас ирүүлсэн чиглэлийн дагуу 2023 оны 10 дугаар сарын 11-ний өдөр Тус соёлын төвийн албан бланк, байгууллагын гаднах хаяг, албан хаагч нарын нэрийн хуудсыг монгол бичгээр үйлдэн хэрэглээнд хэвшүүлэх зэрэг ажлын бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

ТАЙЛАН БИЧСЭН:
СОЁЛ, ГЭГЭЭРЛИЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН  Б.ДОЛГОРМАА